



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/113

Шивээговь сум

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл  
хангуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/251 дүгээр захирамж, 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Л.Бадамханд

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Л.Чанцалмаа

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Б.Доржханд

(Илчлэг-Шивээ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)

П.Ганчимэг

(Эрүүл мэндийн төвийн дарга)

- Д.Буяндэлгэр  
(3 дугаар сургуулийн захирал)
- Б.Даваадолгор  
(3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
- Л.Түмэнцэцэг  
(Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Б.Шинэбаяр  
(Цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа)
- Ж.Чинбат  
(Шивээ Сервис ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

Д.Амартүвшин  
(хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж, аж ахуйн нэгж, албан байгууллага, баг, хөдөөгийн малчин өрх тус бүрээр өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулан биелэлтэнд нь хяналт тавьж, ажлын тайлан, хэрэгжилтийн явцыг хугацаанд нь тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Л.Бадамханд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 1119 захирамжийн хавсралт



### ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах, хяналт тавьж ажиллах байгууллага
<b>Нэг. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар</b>				
1	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах	2024 оны 9 сард	ЗДТГазар ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
2	Сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг бэлтгэх	2024 оны 10 сарын 30	ЗДТГазар ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
3	Сумын бэлчээрийн даацыг тогтоож, хангамж, багтаамжийг тооцох	2024 оны 10 сарын 01	ЗДТГазар, Газрын даамал, ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
4	Малчдад малын индексжүүлсэн даатгалд мал сүргээ хамруулахын ач холбогдлыг таниулах ажлыг зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх	2024 оны 10 сарын 25	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
5	Малчдаар өвс тэжээл, хужир, давс бэлдүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих	2024 оны 8-10 саруудад	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
6	Малчдаар түлээ түлш, дулаан хувцас, өрхийн өвөлжилтийн бэлтгэл хангуулах	2025 оны 8-10 саруудад	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
7	Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол шуурхай дамжуулан, түгээж байх	4 улирлын турш	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
8	Малд үзлэг ангилалт, угаалга, туулгалт, вакцинжуулалтын ажлыг хийгдэх ёстой хугацаанд нь чанартай зохион байгуулах, тайлан мэдээг холбогдох газруудад хүргэх	технологит хугацаанд	ХААТасаг, МЭТ	Ажлын хэсгийн гишүүд

2024



9	Орон нутагт болон отроор өвөлжиж хаваржих малчид, малын тоо толгойн судалгааг гаргах	2024 оны 10 сард	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
10	Сумын хэмжээнд хээлтүүлэгч малын хүрэлцээг судлан, дутагдаж байгааг чанартай хээлтүүлэгчээр хангах, мэргэжлийн ажил үйлчилгээг зохион байгуулж ажиллах	2024 оны 10 сарын 20	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
<b>Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний хэрэгжилтийн дундаж</b>				
<b>Хоёр. Газар тариалангийн чиглэлээр</b>				
11	Ургац хураалтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж шуурхай зохион байгуулах, ААН, айл өрх, иргэдийн хураан авсан үр тариа, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний ургацын мэдээг үнэн зөв гарган холбогдох газруудад тайлан хүргүүлэх	2024 оны 8,9,10-р саруудад	ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
12	Ургац хураалтын явцад тариаланчдыг цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	2024 оны 7,8,9-р саруудад	ХААТасаг, Багийн дарга нар	Ажлын хэсгийн гишүүд
13	Төмс хүнсний ногооны борлуулалтыг дэмжих, орон нутгийн иргэдийг хямд үнэтэй, чанартай ногоогоор хангах, суманд хөдөлмөрлөж байгаа тариаланчдыг олон нийтэд танилцуулах зорилгоор аймагт болох үзэсгэлэн худалдаанд оролцуулах, мэдээлэл дамжуулах	2024 оны 9-р сард	ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
<b>Газар тариалангийн бэлтгэл хангах арга хэмжээний хэрэгжилтийн дундаж</b>				
<b>Гурав.Төв суурин газрын өвөлжилтийн бэлэн байдлыг хангах</b>				
14	Сургууль цэцэрлэг урсгал засварын ажил, анги танхим, өрөө тасалгааны цонх, гадна хаалганы дулаалга хийх, хичээлийн шинэ жилийн нээлтэнд бэлдэх	2024 оны 8 сард	Сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар	Ажлын хэсгийн гишүүд
15	Халаалтын зуухнуудын их засварын ажлыг хугацаанд нь хийх, нүүрсний нөөц бүрдүүлэхэд хяналт тавих, үүрэг чиглэлээр хангах	2025 оны 8 сард	Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	Ажлын хэсгийн гишүүд

16	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын дагуу өвөлжилтийн бэлтгэл ажлын тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэх	2024 оны 9 сард	ХААТасаг	Ажлын хэсгийн гишүүд
17	АБ, ААН байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл байдлын төлөвлөгөөнд хяналт тавьж, үзлэг шалгалт хийж, үр дүнг тооцох	2025 оны 9 сард	Ажлын хэсгийн ахлагч, гишүүд	Ажлын хэсгийн гишүүд
18	Сургууль цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх хүнсний болон мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хүнсний аюулгүй байдлын шинжилгээ тогтмол хийж, үр дүнг тайлагнах	Тухай бүрт	ХААТасаг, МЭТ	Ажлын хэсгийн гишүүд
<b>Төв суурин газрын өвөлжилтийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилтийн дундаж</b>				
<b>Нийт хэрэгжилтийн дундаж</b>				